



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/456

Хэрлэн сум

Зүүн бүсийн анхдугаар чуулганд  
оролцоход дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт, зарцуулалтын журмын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн тахимын Хэнтий аймаг дахь салбар танхимаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Сүхбаатар аймагт 2022 оны 9 дүгээр сарын 28-аас 2022 оны 9 дүгээр сарын 29-д “Бүс нутгийн брэнд бүтээгдэхүүн ба экспортын чиг хандлага” зүүн бүсийн анхдугаар чуулганд брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийг оролцуулахад зориулж 2,000,000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ